

## 2015 оны эхний 8 дугаар сард Цагдаагийн байгууллагад

### ирүүлсэн өргөдөл гомдлын мэдээ

**Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар**


Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2015 оны эхний 8 сард иргэд, байгууллагаас 6284 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 447 нэгж буюу 7.1 хувиар буурсан байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 299 буюу 4.7 хувь нь санал, 5881 буюу 93.5 хувь нь өргөдөл, 104 буюу 1.7 хувь нь гомдол байна.



Өргөдөл, гомдлыг  
утгаар нь авч үзвэл: 825 буюу 13.1 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 209 буюу 3.3 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1125 буюу 18.3 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1670 буюу 26.6 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 288 буюу 4.6 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 2139 буюу 44.8 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 6223 буюу 99.0 хувийг шийдвэрлэж, 61 өргөдлийн үлдэгдэлтэй байна.




**Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар**

2015 оны эхний 8 сард Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 656 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 89 нэгж буюу 13.5 хувиар өссөн байна.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 642 буюу 97.8 хувь нь өргөдөл, 14 буюу 2.2 хувь нь гомдол байна.




Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 60 буюу 9.1 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 15 буюу 2.3 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 55 буюу 8.4 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 190 буюу 29.0 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 31 буюу 4.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 304 буюу 46.3 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



**Гурав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төв ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар**

2015 оны эхний 8 сарын байдлаар иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 297 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 103 буюу 44.1 хувь нь санал хүсэлт, 131 буюу 34.7 хувь нь гомдол, 48 буюу 16.2 хувь нь талархал, 13 буюу 4.4 хувь нь шүүмжлэл, 2 буюу 0.7 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 280 буюу 94.3 хувийг шийдвэрлэж, 17 буюу 5.7 хувь нь ажиллагаанд байна.

**Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар**

2015 оны эхний 8 сард иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 1088 өргөдөл, гомдол хүлээн авч, 1150 алба хаагч холбогдсоны 868 буюу 75.5 хувь нь офицер, 270 буюу 23.5 хувь нь ахлагч, 12 буюу 1.0 хувь нь энгийн алба хаагчид байна. Нийт өргөдөл гомдлын 1033 буюу 95.0 хувийг барагдуулж, 55 буюу 5.0 хувийн үлдэгдэлтэй байна.

